



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар A/14

Батширээт сум

**Чонын үргээлгэ зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 28.1, 35 дугаар зүйлийн 35.1, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалт, Онон багийн Засаг даргын ирүүлсэн хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Онон багийн нутаг дэвсгэрт чонын тоо толгой олширч, мал сүрэгт үлэмж хохирол учруулж байгаа тул 2026 оны 02 дугаар сарын 06-наас 02 дугаар сарын 16-ны өдрийг дуустал хугацаанд чонын үргээлгэ зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. Дээрх нутаг дэвсгэрт зохион байгуулах үргээлгийг галт зэвсгийн аюулгүй ажиллагааны заавар, чоноос бусад ан амьтныг авлахгүй байх талаар нарийн зохион байгуулалтыг хийж явуулахыг Онон багийн Засаг дарга (Д.Хонгорзул)-д үүрэг болгосугай.

3. Авласан чонын төлбөрийг зохих журмын дагуу төсөвт төвлөрүүлэн, баримтыг захирамжид хавсаргахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Мөнх-Очир)-т хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232601027